



**БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ИРГЭНИЙ ХЭРГИЙН АНХАН
ШАТНЫ ШҮҮХИЙН ШҮҮГЧИЙН ЗАХИРАМЖ**

2019 оны 03 сарын 21 өдөр Дугаар 101/ШШ2019/00845

Улаанбаатар хот

Талуудын эвлэрлийг баталж,
хэргийг хэрэгсэхгүй болгох тухай

Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч
Б.Мандалбаяр би,

Нэхэмжлэгч: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 5 дугаа хороо, Үндсэн
хуулийн гудамж, "Ньюмайд групп" ХХК-ийн байр хаягт байрлах "Лендмн ББСБ"
ХХК /рд:5039754/-ийн гаргасан,

Хариуцагч: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 15 дугаар хороо, 13 дугаар
хороолол, 4 дүгээр байр, 133 тоот хаягт оршин суух Цагаан адуут овогт
Нармандахын Чимэдмаа /рд:ЦВ63102667/-д холбогдох,

756,028.04 төгрөг гаргуулах тухай нэхэмжлэлийг 2019 оны 01 дүгээр сарын
25-ны өдөр хүлээн авч хянаад,

ТОДОРХОЙЛОХ нь:

Нэхэмжлэгчээс тус шүүхэд гаргасан нэхэмжлэлдээ:

"Хариуцагч Н.Чимэдмаа нь 2017 оны 07 дугаар сарын 06-ны өдөр цахим
зээлийн эрх нээлгэх гэрээ байгуулсан. Тэрээр 2018 оны 05 дугаар сарын 08-ны
өдөр 700,000.00 төгрөгийг 24,100.00 төгрөгийн шимтгэлтэй, 30 хоногийн
хугацаатай зээлсэн юм.

Гэвч тэрээр уг зээлийг төлөөгүй ба өнөөдрийн байдлаар үндсэн зээл
700,000.00 төгрөг, шимтгэл 24,100 00 төгрөг, нотариатын зардал 31,928.04 төгрөг,
нийт 756,028.04 төгрөг төгрөг болсон.

Иймд, хариуцагчаас дээрх төлбөрийг гаргуулж, манай компанийг хохиролгүй
болгож өгнө үү" гэжээ.

Зохигчид хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад эвлэрлийн гэрээ
байгуулж, хариуцагч тал нэхэмжлэлийн шаардлагаас 500,000.00 төгрөгийг төлсөн,
үлдэх 256,028.04 төгрөгийг 2019 оны 03 дугаар сарын 31-ний өдөр төлөхөөр
болжээ.

ҮНДЭСЛЭХ нь:

Нэхэмжлэгч "Лендмн ББСБ" ХХК-иас хариуцагч Н.Чимэдмаад холбогдуулан
756,028.04 төгрөг гаргуулах тухай нэхэмжлэл гаргасан ба энэ хэрэгт шүүхээс 2019
оны 02 дугаар сарын 1-ний өдөр иргэний хэрэг үүсгэж, хариуцагчид нэхэмжлэлийг

хувийг гардуулж, зохигч нарт хуульд заасан эрх, үүргийг тайлбарлаж, танилцуулсан байна.

Талуудын хооронд байгуулсан эвлэрлийн гэрээг үзвэл хэдийгээр хариуцагч тал нэхэмжлэлийн шаардлага болох 756,028.04 төгрөгийг төлөхийг зөвшөөрч буй боловч нэн даруй бус тодорхой хугацаанд төлөх нөхцөлтэй эвлэрчээ.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.1.-д зааснаар хэрэг үүсгэснээс хойш шүүх хуралдаан хүртэлх хугацаанд зохигчид эвлэрсэн бол шүүх хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэх зорилгоор тэдгээрийн эвлэрлийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгосон захирамж гаргах хуулийн зохицуулалттай.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хариуцагч Н.Чимэдмаа нь нэхэмжлэлийн шаардлагыг үл хүлээн зөвшөөрч, аливаа хэлбэрээр мэтгэлцээгүй, талууд эвлэрч, хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлүүлэх хүсэлт гаргасан байх тул энэхүү хэргийг тус хуулийн 74 дүгээр зүйлд заасан журмын дагуу шийдвэрлэхэд хуульд заасан нөхцөл бүрдсэн гэж үзэв.

Учир нь, энэ хуулийн 26 дугаар зүйлд зааснаар нэхэмжлэгч тал нэхэмжлэлийн шаардлагаа багасгах, нэмэгдүүлэх, өөрчлөх, эвлэрэх эрхтэй бол хариуцагч нь нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх буюу хүлээн зөвшөөрөхөөс татгалзах, сөрөг нэхэмжлэл гаргах, эвлэрэх эрхтэй юм.

Хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэхэд зохигч болон шүүхэд илэрхий байдлаар эрх ашиг нь хөндөгдөж буй гуравдагч этгээд байхгүй, эвлэрэл нь зөвхөн талуудын байгуулсан гэрээний харилцаанаас бий болсон шаардлагын хүрээнд байгаагаас гадна зохигчид эвлэрлийн гэрээнд заасан үүргээ биелүүлээгүйгээс үүсэх үр дагавар нь гагцхүү тэдгээрт хамаарах тул энэхүү эвлэрэл хууль зөрчөөгүй, гуравдагч этгээдийн ашиг сонирхлыг хөндөөгүй байна.

Иймд, нэхэмжлэгч “Лендмн ББСБ” ХХК-ийн гаргасан хариуцагч Н.Чимэдмаад холбогдох иргэний хэрэгт талуудын эвлэрлийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгохоор шийдвэрлэв.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.2, 123 дугаар зүйлийн 123.1 дэх заалтыг тус тус удирдлага болгон

ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нэхэмжлэгч “Лендмн ББСБ” ХХК-ийн гаргасан хариуцагч Н.Чимэдмаад холбогдох 756,028.04 төгрөг гаргуулах тухай нэхэмжлэлтэй иргэний хэрэгт талуудын эвлэрлийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгосугай.


2. Хариуцагч тал нэхэмжлэлийн шаардлагаас 500,000.00 төгрөгийг төлсөн, үлдэх 256,028.04 төгрөгийг 2019 оны 03 дугаар сарын 31-ний өдөр төлөхөөр эвлэрсэн болохыг үүгээр дурдсугай.

3. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.5 дах хэсэгт зааснаар нэхэмжлэгчийн урьдчилан төлсөн тэмдэгтийн хураамж 22,694.00 төгрөгийн тал хувь 11,347.00 төгрөгийг Баянзүрх дүүргийн татварын

хэлтсээс, үлдэх 11,347.00 төгрөгийг хариуцагчаас гаргуулж нэхэмжлэгчид олгосугай.

4. Энэхүү хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэж байгаатай холбогдуулан зохигч давж заалдах болон хяналтын шатны журмаар гомдол гаргахгүйгээс гадна тухайн асуудлаар анхан шатны шүүхэд нэхэмжлэл, гомдол гаргахгүй болохыг тус тус дурдсугай.

5. Захирамжийг зохигч сайн дураар биелүүлэхгүй тохиолдолд шүүхийн шийдвэрийн нэгэн адил албадан гүйцэтгэхийг тэдгээрт мэдэгдсүгэй.

ШҮҮГЧ  Б.МАНДАЛБАЯР